

**“ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ”  
(MON 39229-033) -ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(2020 оны жилийн эцсийн байдлаар)**

2020.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр Огноо, шийдвэрийн дугаар	<b>“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төсөл (MON 39229-033)</b> АХБ-ны Захирлуудын Зөвлөл 2015 оны 9 дүгээр сарын 23-нд баталж, Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 10-нд соёрхон баталсан.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	АХБ-ны хөнгөлөлттэй зээл: <b>50.0 сая ам.доллар</b>
3.	Хэрэгжүүлэгч байгууллага	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)
	Хэрэгжих хугацаа	2016.03.01-2021.06.30
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<b>Төслийн зорилго:</b> Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж (ААН)-үүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй (ХАА), хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулахад оршино. Төслийн үйл ажиллагааны үр дүнд ашиглалтгүй байгаа мал аж ахуй болон ХАА-н бусад баялаг, нөөцийн нэмүү өртгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж дор дурдсан 4 үр дүнг бий болгоно. Үүнд: 1. ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН, хоршоодод нэмүү өртгийн сүлжээ (НӨС)-г хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийгдэнэ; 2. Түүхий эд үйлдвэрлэгч, анхан шатны тордолт, хамгаалалт хийдэг малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэнэ; 3. ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН-үүдийн маркетинг, ажлын арга барил, чадвар, чадавхи дээшилнэ; 4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт.
5.	Зардал Төсөв (Нийт шаардагдах зардал)	АХБ-ны зээл: <b>50.0 сая ам.доллар</b> . Үүнээс: 2020 оны төлөвлөгөө: <b>27,616.8 сая.төг</b> (зээлийн хүү, шимтгэл орсон)

Төслийн гүйцэтгэл 2016-2020 оноор, сая. төгрөг

#	Үр дүн, зардлын зүйл	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он	
		Төсөв	Гүйц.	Төсөв	Гүйц.	Төсөв	Гүйц.	Төсөв	Гүйц.	Төсөв	Гүйц.
<b>1</b>	<b>НӨС-ний хөрөнгө оруулалт</b>	<b>1,717</b>	<b>5,866</b>	<b>32,956</b>	<b>30,797</b>	<b>26,943</b>	<b>26,808</b>	<b>29,527</b>	<b>28,969</b>	<b>22,695</b>	<b>22,217</b>
	АХБ-ны Тусгай сан	-	-	-	-	-	-	6,951	5,650	18,506	18,502
	АХБ-ны Энгийн эх үүсвэр	1,245	5,430	31,914	29,813	25,145	25,019	20,180	20,176	2,109	1,667
	Сургалт	80	47	88	31	30	27	141	42	36	4
	Зөвлөх үйлчилгээ	302	302	466	465	477	473	530	505	496	496
	АХБ-ны зээлийн хүү	90	87	488	488	1,290	1,290	1,726	2,596	1,548	1,548
<b>2</b>	<b>Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>37</b>	<b>35</b>	<b>2,410</b>	<b>68</b>	<b>1,182</b>	<b>944</b>	<b>2,484</b>	<b>1,645</b>
	Ажил	-	-	-	-	320	-	-	-	1,661	1,213
	Тоног төхөөрөмж, бараа материал	-	-	-	-	2,000	-	925	734	440	195
	Сургалт, судалгаа	-	-	37	35	90	68	257	211	383	237
<b>3</b>	<b>ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>424</b>	<b>407</b>	<b>3,670</b>	<b>382</b>	<b>3,696</b>	<b>3,315</b>	<b>1,151</b>	<b>490</b>
	Тоног төхөөрөмж, бараа материал	-	-	267	267	3,000	90	3,003	2,772	100	96
	Сургалт, судалгаа	-	-	156	140	670	292	694	544	1,051	394
<b>4</b>	<b>Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт</b>	<b>13</b>	<b>12</b>	<b>35</b>	<b>21</b>	<b>631</b>	<b>148</b>	<b>829</b>	<b>643</b>	<b>808</b>	<b>309</b>
	Сургалт, судалгаа	-	-	1	-	310	148	305	304	342	105
	Брэнд хөгжүүлэх ажиллагаа	13	12	34	21	321	-	524	340	467	205
<b>5</b>	<b>Төслийн удирдлага</b>	<b>342</b>	<b>288</b>	<b>548</b>	<b>450</b>	<b>741</b>	<b>398</b>	<b>490</b>	<b>397</b>	<b>479</b>	<b>311</b>
	<b>Нийт дүн</b>	<b>2,072</b>	<b>6,165</b>	<b>34,000</b>	<b>31,710</b>	<b>34,395</b>	<b>27,804</b>	<b>35,724</b>	<b>34,269</b>	<b>27,617</b>	<b>24,972</b>

6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтын биелэлт:	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн үйл ажиллагаа 2016 оны 03-р сарын 01-ээс эхэлсэн.
	<b>Үр дүн 1:</b> ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН, хоршоодод нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх	<p>- Арилжааны 6 банк (ХААН, ХАС, ХХБ, Голомт, ҮХОБ, УБ хотын)-тай Дамжуулан зээлдүүлэх гэрээг СЯ байгуулснаар НӨС-г хөгжүүлэх зээл олгох ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Арилжааны банк, ЗБДС-ийн ажилтнууд, ААН-үүд болон бусад сонирхогч талуудын төлөөлөлд шат дараалсан 68 сургалтад давхардсан тоогоор нийт 1269 ААН, байгууллагын 3336 ажилтан хамрагдсан. Үүнээс: <b>2020</b> онд ТОААН/төсөлд оролцогч аж ахуйн нэгж/-ийг чадавхжуулах дижитал маркетинг, компанийн засаглалын 2 удаагийн семинар, сургалтад 40 ААН-ийн 75 төлөөлөл хамрагдсан.</p> <p>-Банкны зээлийн хороогоор батлан ирүүлсэн 62 дэд төсөл хүлээн авч, 49 төсөлд бизнесийн, санхүү, байгаль орчны болон нийгэм, жендэрийн 4 төрлийн иж бүрэн үнэлгээг хийж, 45 дэд төслийг АХБ болон ТУХ-оор батлуулсан.</p> <p><b>2016-2020 онд:</b> нийт 106,757.1 сая төгрөгийн өртөгтэй 45 зээл баталж, 44 төслийн 106, 257.1 сая төгрөгийн санхүүжилтийг Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу олгосон байна.</p> <p><b>2020 онд:</b> 19.9 тэрбум төгрөгийн өртөгтэй 8 дэд төслийн иж бүрэн үнэлгээг хийж, АХБ болон ТУХ-оор батлуулж, 7 дэд төслийн 19,368.0 сая, 2019 оны 1 зээлийн үлдэгдэл санхүүжилт 800.0 сая, нийт 20,168.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2020 оны эцсээр батлагдсан 1 зээлийн санхүүжилтийг 2021 онд олгох болсон.</p> <p>-Ковид-19 цар тахалтай холбогдуулан зээлд хамрагдсан ААН-үүд зээлийн хугацааг хойшлуулж, эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах санал ирүүлснээс ТУХ-нд 7 хүсэлтийг танилцуулж, 4 ААН-ийн зээлийн хугацааг хойшлуулж, эргэн төлөлтийг хуваарьт өөрчлөлт оруулсан.</p> <p>Нэмэлт санхүүжилтийн үед олгогдсон зээлийн хүүгийн төлбөр гэрээний дагуу хугацаандаа хийгдэж байна. Төслийн эхний шат (2009-2015 он)-д олгосон дэд төслүүдийн зээлийн эргэн төлөлт бүрэн хийгдэж, эргэн төлөлтийн 23.1 тэрбум төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.</p> <p>Нэмэлт санхүүжилтийн үед олгогдсон зээлийн хүүгийн төлбөр гэрээний дагуу хугацаандаа хийгдэж байна.</p> <p>- Төслөөс дэд төслүүдийн хэрэгжилтэд мониторинг тогтмол хийж байна. Нэг дэд төслийн хэрэгжилтэд саатал үүссэн нь зээлийн эргэн төлөлтийн хувьд аливаа эрсдэл байхгүй боловч нэмүү өртгийн сүлжээнд хийхээр төлөвлөсөн ажлуудаа гүйцэтгэж чадахгүй байх нөхцөл байдалд байна.</p> <p>-Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалж төлөвлөсөн сургалтууд цуцлагдсан нь уг дэд хэсгийн хэрэгжилтийг бүрэн хангахад нөлөөлсөн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
	<b>Үр дүн 2-4-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллах Техник туслалцаа (ТТ)-ны гадаадын болон дотоодын зөвлөх бүхий баг нь 2017 оны 3-р сараас эхэлсэн бөгөөд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна.</b>	
	<b>Үр дүн 2:</b> Түүхий эд үйлдвэрлэгч, анхан шатны тордолт, хамгаалалт хийдэг малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.	<p><b>Төсөв:</b> 2017-2020 онд нийт 2,692.3 сая төгрөг, үүнээс 2020 онд 1,645.0 сая төгрөгийг зарцуулсан. 2020 оны төсвийн гүйцэтгэл 66.2%.</p> <p><b>Бүрэлдэхүүн хэсгийг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд:</b></p> <p>- ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаанд арьс шир, ноос ноолуур, оёдол, мах, сүү, зөгий болон чацарганы дэд салбар хамаарах бөгөөд дэд салбар тус бүрийн хэрэгцээг тодорхойлсон судалгаа хийсэн.</p> <p>- Малчдын хоршоодыг сонгох ажлын хүрээнд ТОААН-дэд түүхий эд нийлүүлдэг малчид, хоршоод, анхан шатны үйлдвэрлэгчдийн байршлын судалгааг хийсэн.</p>

<p>Энэ ажлын хүрээнд малчид, малчдын хоршоод, бэлтгэн нийлүүлэгчдэд чиглэсэн сургалт, судалгаа, тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг ажлуудыг хийнэ.</p>	<p><b>Сургалт:</b> Ноос ноолуур, мах, сүү, арьс шир, зөгий, чацарганы салбарын ГОААН-үүд, түүхий эд бэлтгэн нийлүүлдэг малчид, малчдын хоршоод, бэлтгэн нийлүүлэгчдэд зориулж, <i>төслөөс өссөн дүнгээр 94.7 мян.ам.долл-ын 35 удаагийн сургалт зохион байгуулж нийт 1,356 малчид, анхан шатны боловсруулагчдыг хамруулсан. 2020 онд: 23.1 мян.ам.долл-ын 3 удаагийн сургалт зохион байгуулж 185 хүн хамруулсан.</i> Сургалтыг мах, махан бүтээгдэхүүний мал эмнэлэг-ариун цэвэр, чацаргана болон жимст цэцэрлэгийн талбайн хамгаалалтын ойн зурвасын сургагч багш бэлтгэх, сүү бэлтгэхэд баримтлах зохистой дадал, өрхийн нөхцөлд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургагч багш бэлтгэх зэрэг сэдвээр явуулсан байна.</p> <p><b>Түршилт, судалгааны ажлууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт явуулах” гэрээт ажил хэрэгжиж дууссан. Энэ хүрээнд 6 (Хэнтий, Сүхбаатар, Завхан, Хөвсгөл, Архангай, Баянхонгор) аймгийн 19 сум, нийслэлийн 2 (Налайх, Сонгинохайрхан-Эмээлт) дүүргийн 850 малчид, хоршоологчид, түүхий эд бэлтгэгчид, аймгийн МЭГ, ХХААГ-ын ажилтнууд, малын эмч нарыг 2 шатны 6 модультай 336 цагийн сургалтад хамруулсан.</li> <li>- “Боловсруулах үйлдвэрүүдийн стандартын шаардлага хангасан арьс, ширэн түүхий эдийн технологийн дагуу бэлтгэн нийлүүлэх чиглэлээр мэдлэг олгох, мэдээлэл өгөх видео сургалт, баримтат кино бэлтгэн олон нийтийн мэдээллийн сувгаар хүргүүлэх” гэрээт ажил дуусч, 5 минутын видео хичээлийг Малчин ТВ, ТВ9, MN25 сувгуудаар нийт 90 минутын туршиж цацаж, зорилтот бүлэгт хүргэсэн.</li> <li>- “Мал, амьтанд төхөөрөхийн өмнө болон төхөөрсний дараа мал эмнэлэг - ариун цэврийн үзлэг, шалгалт явуулах стандарт ажиллагаа”-ны заавар 22 минутын видео хичээлийг бэлтгэсэн.</li> <li>- Чацарганын салбарын MNS6849:2020 “Жимст цэцэрлэгийн талбайн хамгаалалтын ойн зурвас. Техникийн шаардлага”, MNS6850:2020 “Жимс, жимсгэнийн үржүүлгийн эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийхэд тавих шаардлага” гэсэн 2 стандартыг 2020.06.30-нд СХЗГ-аар батлуулсан.</li> <li>- Мах, махан бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, худалдааны аюулгүй байдлыг хангах, хүн, мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолыг хамгаалах зорилготой 10 бүлэг, 45 зүйл, 623 заалт, 6 хавсралттай махны салбарын техникийн зохицуулалтын гарын авлагыг боловсруулж, хэвлүүлсэн.</li> <li>- “Зөгийн бэлчээрийн менежментийг сайжруулах”, “Зөгийн бүлийг ургамлын тоос хүртээлтэд ашиглах”, “Зөгийн аж ахуйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх” судалгааны ажлууд хэрэгжиж дууссан.</li> <li>- “Чацаргана болон бусад жимс жимсгэнийн ургамлын генефонд байгуулах” гэрээт ажил дууссан. Энэ ажлын дүнд монгол орны байгалийн чацаргана бүхий 6 аймгийн 10 гаруй сумын чацарганын нутгийн хэлбэрүүдээс шилж, цаашид селекцид ашиглах боломжтой 20 гаруй дээж хэлбэрүүдийг ногоон мөчрөөр үржүүлэн нийт 20 мянга гаруй суулгац бэлтгэсэн.</li> </ul> <p><b>Бараа материал, тоног төхөөрөмж худалдан авах:</b> Бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажлын гэрээг байгуулж, 102.1 сая төгрөгийн 4 аймгийн (Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Дорноговь) 82 бэлчээрт усны хайгуулын ажил хийгдсэн.</p> <p>12 аймагт 61 худаг гаргах 1.6 тэрбум төгрөгийн 11 гэрээ байгуулан ажиллаж байна. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар 1.1 тэрбум төгрөгийн гэрээт</p>
---	---

	<p>ажлыг санхүүжүүлсэн. Архангай, Баянхонгор, Завхан, Сүхбаатар, Ховд болон Хэнтий аймгуудад нийт 45 худаг гаргах ажил бүрэн дууссан, Говь-Алтай, Увс аймгуудад тендерт орох ААН-үүд орж ирээгүйгээс шалтгаалж 2 удаа зарлагдан хугацаа хойшлогдон барилгын ажил үлдсэн, зарим цооногоос ус гарахгүй дахиж өрөмдөх зэрэг шалтгаанаар 16 худгийг барих ажлын гэрээг ХХААХҮЯ-ны МААХБЗГ-ын холбогдох мэргэжилтнээр хянуулан гэрээг 2021 оны 05 дугаар сарын 15-ныг хүртэл хугацааг сунгасан. Тус газраас худгийн ажлын явцтай газар дээр нь хянаж танилцан, дүгнэлт гарган холбогдох гүйцэтгэлд санхүүжилтийг олгуулсан байна.</p> <p>2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 906.3 сая төгрөгийн өртөгтэй арьс шир халимлах машин, сүүний чиглэлийн хоршоодод сүү боловсруулах иж бүрдэл, ноосны хоршоог чадавхижуулах багаж, хэрэгсэл болон зөгийн салбарын хоршоодод зөгийн гэр, сэмж нийлүүлсэн байна. ХШҮ-90%</p> <p>Малчид, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор нийтдээ 1.2 тэрбум төгрөгийн цахилгаан хөдөлгөөнт саалтуур, сүүний хөргөлтийн танк, лактоскан (сүү шинжлэгч багаж) болон барометр худалдан авах нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, 2020 оны 10-р сарын 14-ний өдөр нээж, тендерийн үнэлгээ хийгдэж тухайн тендер хүчингүй болсон. Уг санхүүжилтийг ХХААХҮЯ-наас тавьсан хүсэлтийн дагуу АХБ-нд уламжилснаар зудад нэрвэгдсэн аймгуудад хүнсний(гурил, будаа, элсэн чихэр г.м) бүтээгдэхүүн нийлүүлэхээр 2021 оны 1 сард зохион байгуулсан. ХШҮ-77.5%</p>
<p><b>Үр дүн 3:</b> ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН-үүдийн маркетинг, ажлын арга барил, чадвар, чадавхийг дээшлүүлэх.</p> <p>Энэ ажлын хүрээнд 1.0 сая орчим ам.долларын тоног төхөөрөмж худалдан авч, 500 гаруй мянган ам.долларын сургалт, судалгаа, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлууд хийгдэнэ.</p>	<p><b>Төсөв:</b> 2017-2020онд нийт 4,594.0 сая төгрөг, үүнээс 2020 онд 490.0 сая төгрөгийг зарцуулсан байна. 2020 оны төсвийн гүйцэтгэл 42.6%.</p> <p><b>Бүрэлдэхүүн хэсгийг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ТООАН-үүдийг сонгон шалгаруулах үзүүлэлтүүдийг ерөнхий болон тусгайлсан гэсэн хоёр чиглэлээр салбар тус бүрээр гарган батлуулж, сонгон шалгаруулалтыг хийж ХХААХҮЯ-ны ТНБД-ын тушаалаар байгуулсан Техникийн зөвлөх нэгж (ТЗН)-ээр батлуулсан.</li> <li>- Зорилтот дэд салбаруудад чиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийн техникийн чадавхийг бэхжүүлэх, дотоодын болон экспортод чиглэсэн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилтын хүрээнд ТООАН-ээр сонгогдох ААН-д сонгон шалгаруулалтын дагуу үнэлгээ хийж ерөнхий жагсаалт гарган ТЗН-ийн хуралдаанд хэлэлцүүлж, 7 дэд салбарын нийт 64 ААН хамрагдахаас бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр 35 ААН-ийг сонгосон. Салбарын ЭШХ-үүдийн лабораторийн хүчин чадал, чадамжийг сайжруулах хүрээнд нийлүүлэгдэх 63 нэр төрлийн тоног төхөөрөмж, лабораторийн багаж хэрэгсэл, эм урвалжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан.</li> </ul> <p><b>Сургалт:</b> ТООАН-ийн мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр <i>төслөөс нийт 70.5 мян.ам.долл-ын 39 сургалт зохион байгуулж, 1270 хүнийг хамруулсан.</i></p> <p><b>2020 онд:</b> 25.3 мян.ам.долл-ын 6 сургалтад 357 хүн хамрагдсан. Эдгээр сургалт нь ААН-ийн сүлжмэлийн зохион бүтээлт, сүлжих автомашинуудын техник, технологийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, хүүхдийн гутлын масс үйлдвэрлэлийн ажлын байрны сургалт, мах махан бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл, нэхмэлийн техникийн гарын авлага ба мэргэжилтний ур чаварыг дээшлүүлэх, мах махан бүтээгдэхүүний гадаад, дотоод худалдаан дахь эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдал, чанарын шаардлагууд зэрэг сэдвээр зохион байгуулагдсан байна.</p>

**Туршилт, судалгааны ажлууд:**

- “Сүү, сүүн бүтээгдэхүүний стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох”, “Олон улсын стандартуудын сургалт (чацаргана)”, “Чацарганы кластерийн хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх нэгдсэн өртгийн сүлжээ үүсгэх судалгаа”, “Бэлчээрийн монгол малын сүүний хими, биохимийн найрлагыг тогтоох, түүгээр зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх туршилт, судалгаа”, “Зөгийн уурагт тэжээлийн технологи боловсруулах үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Зөгийн хачигтах өвчний үед хэрэглэх шинэ эмүүдийн технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Зөгийн гэр болон зөгийн аж ахуйн нэр томъёоны стандартуудыг шинээр боловсруулж батлуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Монгол зөгийн балны биологийн онцлог, антиоксидант чанарыг тогтоох” судалгааны ажлууд хийгдэж дууссан.

- Нэхмэлийн салбарын “Монголын сүлжмэлийн үйлдвэрүүдийн гүйцэтгэн боловсруулалт”, “Ноосон нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалтын технологи”, “Чанарын баталгаажилт ба хяналт”, “Ноос ноолуурыг будах техник, технологи” нийт 281 хуудас 4 гарын авлагыг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж, хөрвүүлэх ажил хэрэгжиж дууссан. Уг гарын авлагуудын талаарх нарийвчилсан техникийн хэлэлцүүлгийг 2020.11.10-ны өдөр ХХААХҮЯ, ШУТИС, үйлдвэрлэл эрхлэгчид зэрэг мэргэжлийн экспертүүдийг оролцоотой зохион байгуулсан.

-“Сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх технологийн ажиллагааны сургалтын видео материал бэлтгэх олшруулах” гэрээт ажил дуусч, үндэсний стандартад нийцсэн сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх үйлдвэрлэлийн технологи ажиллагааны 13 нэр төрлийн хувцас (анги, хүйс) нийт 188:19 минутын хугацаатай, 22GB хэмжээтэй видео хичээлийг бэлэн болгосон.

-“Компанийн нийгмийн хариуцлага, ёс зүй” дадлагажуулах сургалтын гэрээт ажил, “Монгол зөгийн балыг сурталчилахад зориулсан цахим ном, видео контент бэлтгэх” ажил, “Шувуу үргээх төхөөрөмжийн ажиллагаа техникийн туршилт хийж ашиглалтын үр ашгийг тооцоолох үйлдвэрлэлд нэвтрүүлэх”, “Монголын хаан ширхэгтийн бүтээгдэхүүн хөгжүүлэх загвар туршилтын түүхий эдийн чанарыг шинжилж, үнэлэн анхдагч өгөгдлүүдийг бүрдүүлэх”, “Бэлчээрийн монгол малын мах, махан бүтээгдэхүүн нь зохицуулах үйлчилгээтэй хүнс болохыг баталгаажуулах судалгаа”, “Чацаргана, түүний гаралтай бүтээгдэхүүний тэжээллэг ба эмчилгээний шинж чанарыг тогтоох судалгаа” зэрэг томоохон туршилт, судалгааны ажлууд хэрэгжиж байна.

-Оёдлын салбарын 3, сүүний салбарын 3, зөгийн салбарын 4 стандартыг тус тус боловсруулж, СХЗГ-аар батлуулсан.

**Бараа материал, тоног төхөөрөмж худалдан авах:** 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 3.0 тэрбум төгрөгийн өртөгтэй арьс шир, ноос ноолуур, оёдол, зөгий, чацарганы салбарын лабораторийн тоног төхөөрөмж болон мах, сүүний чиглэлийн шилмэл үүлдрийн гүн хөлдөөсөн үр, хөврөл нийлүүлсэн.

Тайлант онд салбарын ЭШБ-дад 95.7 сая төгрөгийн чацарганы талбайн шавьж баригч наалтын тоног төхөөрөмжийн түүхий эд, зөгийн бүтээгдэхүүнийг баталгаажуулах лабораторийн урвалжийг нийлүүлсэн.

ХШҮ-90%

<p><b>Үр дүн 4:</b> Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх замаар бүрэн ашиглалтгүй байгаа МАА болон ХАА-н бусад баялаг нөөцийн нэмүү өртгийг нэмэгдүүлэх (үнэ цэнийг дээшлүүлэх)-эд дэмжлэг үзүүлэх.</p> <p>Энэ ажлын хүрээнд экспортын баримжаатай бөгөөд төсөлтэй хамтран ажиллахаар сонгогдсон ААН-тэй тусгайлсан хөтөлбөрийн дагуу шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, брэндийн хөгжүүлэлт болон бусад сургалт, судалгааны ажлууд хийгдэнэ. Энэ ажлын хүрээнд 300 орчим мянган ам.долларын брэнд хөгжүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлж, 350 гаруй мянган ам.долларын сургалт, судалгааны ажлууд хийгдэнэ.</p>	<p><b>Төсөв:</b> 2016-2020 онд нийт 1,133.0 сая төгрөг, үүнээс 2020 онд 309.0 сая төгрөгийг зарцуулсан. 2020 оны төсвийн гүйцэтгэл 38.2%.</p> <p><b>Бүрэлдэхүүн хэсгийг эхлүүлэх бэлтгэл ажын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын болон үндэсний экспертүүд дэд салбар тус бүрт чиглэсэн брэнд болох ба экспортлох боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлох, улмаар тэдгээрийн экспорт, импортод тавигдах шаардлага, хөгжиж буй улс орны өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлэх туршлагын чиглэлээр судалгаа хийсэн.</li> <li>- Брэнд хөгжүүлэх болон экспортод гарах боломжтой дэд салбар тус бүрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа болон сургалт судалгааны чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг холбогдох талуудтай эцэслэж, ТУХ-оор дэмжүүлэн АХБ-нд хүргүүлсэн.</li> <li>- Дотоод болон гадаадад брэнд болохуйц бүтээгдэхүүн бий болгох болон хөгжүүлэх загвар төслийн үйл ажиллагааны хүрээнд үнэлгээ хийн Ажлын нарийвчилсан төлөвлөгөөг дэд салбар тус бүрээр гаргасан байна.</li> <li>- Дотоодын болон экспортод чиглэсэн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр ноос ноолуур, арьс шир, оёдол, мах, зөгий болон чацарганы салбарын 35 аж ахуйн нэгжийг сонгосон.</li> <li>- 2018-2020 онд хийгдэх судалгааны ажлын даалгавар, сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.</li> </ul> <p><b>Сургалт:</b> Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх үйл ажиллагааны талаар <i>төслөөс 2016-2020 онд нийт 17.4 мян.ам.долл-ын 12 сургалт зохион байгуулж, нийт 351 хүн хамруулсан.</i> Сургалт нь дотор махны зохистой хэрэглээ, бүтээгдэхүүний суулт тохироо, экспортын чанарын шаардлага хангасан зөгийн бал үйлдвэрлэх, удирдлагын тогтолцооны дотоод аудитор бэлтгэх, зөгийчдийн ур чадварыг дээшлүүлэх, “Монголын Хаан Ширхэгт” гэрчлэх тэмдэгт стандартын эхний төслийг танилцуулж, ОУ-ын хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүдийг тогтоох зэрэг сэдвээр зохион байгуулагдсан. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд дагаж мөрдөх техникийн зохицуулалтын баримт боловсруулах ажлын хэсгийн 3, 4-р хуралдааныг зохион байгуулсан.</p> <p><b>Түршилт, судалгааны ажлын хүрээнд:</b></p> <p>“Чацарганы бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа”, “Ноосон даавуун хүрэм үйлдвэрлэх”, “Монголын хаан ширхэгт гэрчлэх тэмдэгт бүтээгдэхүүний үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавигдах техникийн баримт бичиг боловсруулж, хүний нөөцийг чадавхжуулах”, “Бэлчээрийн монгол малын сүүний хими, биохимийн найрлагыг тогтоох, түүгээр зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх туршлага, судалгаа”, “Монголын хаан ширхэгт тэмдэгт сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартуудыг боловсруулж, батлуулах”, “Монголын Хаан ширхэгт гэрчлэх тэмдэгт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоод хяналтын сорилтын лабораторийн итгэмжлэлийн үйл ажиллагаанд шаардагдах техникийн баримт бичиг боловсруулж, хүний нөөцийг чадавхжуулах”, “Арьс ширний салбарын ТООАН-дэд үйлдвэрлэлийн зөв тогтолцоо бүрдүүлэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх”, “Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын баталгаажуулалтын аудит хийлгэх”, “Сурагчийн дүрэмт хувцас үндэсний стандартыг нийтэд танилцуулах контент бэлтгэх сурталчлах”, “Махны техникийн зохицуулалтын лавлагаа баримт бичгүүдийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулах”, “Зөгийн аж ахуйд хөдөө аж ахуйн зохистой дадал</p>
---	--

		<p>нэвтрүүлэх стандарт, үнэлгээний хуудас боловсруулах баталгаажуулах”, “Зөгийн аж ахуйн технологий, менежмент сургалтын цуврал видео хичээл хийх”, “Зөгийн аж ахуйн зөвлөх/сургагч багш нарт зориулсан удирдлагын тогтолцооны дотоод аудитор (ISO19011) бэлтгэх”, “Брэнд болон экспортын чанарын шаардлага хангасан зөгийн бал үйлдвэрлэх загвар бий болгох хүрээнд бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхижуулах”, “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм боловсруулах баталгаажуулах”, “Зөгийг ургамлын тоос хүртээлтэд ашиглах эдийн засгийн өгөөжийг тооцох аргачлал, зөгийн болон балт ургамлын тариалангийн хосолсон болон дагнасан аж ахуй хөгжүүлэх боломж судалгаа” зэрэг гэрээт туршилт, судалгааны гэрээт ажлууд хийгдэж дууссан.</p> <p>“Монгол зөгийн балыг Европын холбооны орнуудад экспортлох боломжид судалгаа хийж дэмжлэг үзүүлэх”, “Үйлдвэрлэлийн дотоод хяналтын лабораторийн шинжээч бэлтгэх сургалт”, “Монгол орны байгалийн чацарганы олон янз байдал тэдгээрийн генетикийн онцлог шинжүүдийг уламжлалт болон орчин үеийн молекул генетикийн судалгааны аргаар харьцуулан судлах”, “Монголын хаан ширхэгт тохиролын тэмдэг бүхий бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажилт-шаталсан сургалт”, “Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, үйлдвэрлэл төрөлжүүлэх судалгаа“ зэрэг гэрээт ажил хийгдэж байна.</p> <p>Махын салбарын 1, зөгийн салбарын 1, арьс ширний салбарын 2, чацарганы салбарын 2 аж ахуйн нэгж ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлж, батламжилсан гэрчилгээ авсан.</p> <p>"Монголын хаан ширхэгт" гэрчлэх тэмдгийг нэвтрүүлэхээр ХХААХҮЯ болон МННХ-той хамтран ажиллаж байна. МХШ брэндийн удирдамж, гарын авлага боловсруулж, МХШ-ийн стандарт батлуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-83.3%</p>
	<p><b>Төслийн удирдлага:</b></p> <p>Төслийн хэрэгжилт, хяналтын удирдлагыг үр дүнтэй хийх.</p>	<p>Төслийн удирдах хороо (ТУХ)-ны бүтэц, бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2020.11.03-ны өдрийн А-356 тоот тушаалаар ХХААХҮЯ-ны 7, СЯ-ны 2, БОАЖЯ-ны 1, Монгол банкны 1 төлөөллөөр тус тус бүрдүүлэн, төслийн хэрэгжилтэд ерөнхий хяналт тавин ажилласан.</p> <p>ЗГ-ын 2019 оны 87-р тогтоолын дагуу тус төслийг хэрэгжүүлэгч нь СЯ-наас ХХААХҮЯ-нд шилжиж, тус 2 яамны хооронд 2020.05.13-ны өдөр Дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан.</p> <p>“Төслийн Удирдах хорооны үйл ажиллагааны журам”-ыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Төсөл хэрэгжих хугацаанд ТУХ нь 21 удаа хуралдаж төслийн талаарх асуудлыг хэлэлцэн шаардлагатай шийдвэр, зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Төслийн удирдах нэгж (ТУН) нь захиргааны ажилтан 5, үндэсний зөвлөхийн 6 орон тоотой. Үр дүн 2, 3, 4-ийн үйл ажиллагааг хариуцсан ТА8960 Техник туслалцаа (ТТ)-ны гадаадын болон дотоодын зөвлөх бүхий баг ажиллаж байгаатай холбогдуулан тус төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог ханган ажиллахад анхаарч ажиллаж байна.</p> <p>ТУН-ийн ажилтнууд болон зөвлөхүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалд заасны дагуу боловсруулан, мөрдөж ажиллаж байна.</p> <p>ТУН-ийн дотоод журам, НӨС-г хөгжүүлэх зээл олгох журмыг батлан, төслийн үйл ажиллагаандаа мөрдөн, МУ-ын хууль тогтоомж, АХБ-ны бодлого журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p>

		<p>Төслийн вэб-хуудсыг монгол, англи хэл дээр ажиллуулан, вэб-хуудсаар дамжуулан төслийн талаарх бүх төрлийн мэдээллийг төсөлд оролцогч болон сонирхогч байгууллага, хувь хүмүүст хүргэж байна. Мөн Шилэн дансны вэб-хуудас болон СЯ-ны Төслийн удирдлагын мэдээллийн сангийн ODAMIS системд мэдээллээ байнга байршуулж байна.</p> <p>Төслийн үйл ажиллагааны хяналт, мониторинг хийх, тайлагнах үйл ажиллагаа ЗГ-ын болон Сангийн сайдын холбогдох журмуудын дагуу чиглэл тус бүрээр хувиарийн дагуу хийгдэж байна.</p> <p>Төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд АХБ, яамдууд, мэргэжлийн холбоод, ЭШБ болон хувийн хэвшилтэй нягт ажиллахаас гадна олон улсын санхүүгийн байгууллага, донор орнууд, гадаадын бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байна.</p> <p><b>Төсөв:</b> 2016-2020 онд нийт 1.844.0 сая төгрөг, үүнээс 2020 онд 311.0 сая төгрөгийг зарцуулсан. 2020 оны төсвийн гүйцэтгэл 64.9%-тай байна.</p>																																																																																																																																					
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>1. Төсөл нь 15 аймаг, 42 сум, 7 дэд салбарт ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байр бий болгохоор тавьсан зорилгоо биелүүлж байна хэмээн үзэж, төслийн 2020 оны жилийн ажлын гүйцэтгэлийг <b>86.5 хувь</b> буюу <b>“Тодорхой үр дүнд хүрсэн”</b> үнэлгээгээр дүгнэгдэв.</p> <p>Тайлант онд төслийн нийт гүйцэтгэлийг 100%-д хүрнэ гэж төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахлын улмаас төлөвлөгдсөн зарим ажлууд хийгдэх боломжгүй болж цуцлагдсан, зарим ажлын хэрэгжилт хойшлогдон он дамжсан зэрэг бодит шалтгаанаас төслийн нийт бодит гүйцэтгэл 2020.12.31-ний өдрийн байдлаар 97.1%-д хүрсэн.</p> <p><b>Төслийн нийт гүйцэтгэл (мян.доллар)</b></p> <table border="1" data-bbox="547 1048 1474 1272"> <thead> <tr> <th rowspan="2">Үр дүн</th> <th colspan="3">Төслийн нийт</th> </tr> <tr> <th>Төлөвлөгөө</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td><b>1. АХБ-ны санхүүжилт</b></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>1. Нэмүү ертгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх</td> <td>44,870.7</td> <td>44,715.5</td> <td>99.7%</td> </tr> <tr> <td>2. Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг</td> <td>1,744.8</td> <td>1,001.7</td> <td>57.4%</td> </tr> <tr> <td>3. ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</td> <td>1,794.5</td> <td>1,610.8</td> <td>89.8%</td> </tr> <tr> <td>4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт</td> <td>674.1</td> <td>415.7</td> <td>61.7%</td> </tr> <tr> <td>5. Төслийн удирдлага</td> <td>727.5</td> <td>604.6</td> <td>83.1%</td> </tr> <tr> <td><b>АХБ-ны дүн</b></td> <td><b>49,811.6</b></td> <td><b>48,348.3</b></td> <td><b>97.1%</b></td> </tr> </tbody> </table> <p>2. Төслийн 2020 оны батлагдсан төсөв нь 27,616,797.1 мян.төг, гүйцэтгэлээр 24,972,123.4 мян.төг буюу 90.4%-ийн биелэлттэй байна.</p> <p><b>Төслийн 2020 оны гүйцэтгэл (мян.төг)</b></p> <table border="1" data-bbox="547 1361 1474 1868"> <thead> <tr> <th rowspan="2">#</th> <th rowspan="2">Үр дүн, зардлын зүйл</th> <th colspan="3">2020 он (мян. төг)</th> </tr> <tr> <th>Төсөв</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td><b>1</b></td> <td><b>НӨС-ний хөрөнгө оруулалт</b></td> <td><b>22,695,049.4</b></td> <td><b>22,217,315.7</b></td> <td><b>97.9</b></td> </tr> <tr> <td></td> <td>АХБ-ны Тусгай сан</td> <td>18,505,635.6</td> <td>18,501,784.7</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>АХБ-ны Энгийн эх үүсвэр</td> <td>2,109,355.3</td> <td>1,667,015.3</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Сургалт</td> <td>35,878.1</td> <td>4,362.3</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Зөвлөх үйлчилгээ</td> <td>496,464.1</td> <td>496,437.2</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>АХБ-ны зээлийн хүү</td> <td>1,547,716.3</td> <td>1,547,716.3</td> <td></td> </tr> <tr> <td><b>2</b></td> <td><b>Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх</b></td> <td><b>2,483,547.4</b></td> <td><b>1,644,989.7</b></td> <td><b>66.2</b></td> </tr> <tr> <td></td> <td>Ажил</td> <td>1,661,035.0</td> <td>1,213,051.4</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Тоног төхөөрөмж, бараа материал</td> <td>440,000.0</td> <td>195,356.8</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Сургалт, судалгаа</td> <td>382,512.4</td> <td>236,581.5</td> <td></td> </tr> <tr> <td><b>3</b></td> <td><b>ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</b></td> <td><b>1,151,166.9</b></td> <td><b>489,733.8</b></td> <td><b>42.5</b></td> </tr> <tr> <td></td> <td>Тоног төхөөрөмж, бараа материал</td> <td>100,000.0</td> <td>95,708.8</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Сургалт, судалгаа</td> <td>1,051,166.9</td> <td>394,025.0</td> <td></td> </tr> <tr> <td><b>4</b></td> <td><b>Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт</b></td> <td><b>808,472.8</b></td> <td><b>309,445.7</b></td> <td><b>38.3</b></td> </tr> <tr> <td></td> <td>Сургалт, судалгаа</td> <td>341,575.4</td> <td>104,746.3</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Брэнд хөгжүүлэх ажиллагаа</td> <td>466,897.4</td> <td>204,699.4</td> <td></td> </tr> <tr> <td><b>5</b></td> <td><b>Төслийн удирдлага</b></td> <td><b>478,560.7</b></td> <td><b>310,638.4</b></td> <td><b>64.9</b></td> </tr> <tr> <td></td> <td><b>Нийт дүн</b></td> <td><b>27,616,797.2</b></td> <td><b>24,972,123.4</b></td> <td><b>90.4</b></td> </tr> </tbody> </table>	Үр дүн	Төслийн нийт			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	<b>1. АХБ-ны санхүүжилт</b>				1. Нэмүү ертгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх	44,870.7	44,715.5	99.7%	2. Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг	1,744.8	1,001.7	57.4%	3. ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	1,794.5	1,610.8	89.8%	4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт	674.1	415.7	61.7%	5. Төслийн удирдлага	727.5	604.6	83.1%	<b>АХБ-ны дүн</b>	<b>49,811.6</b>	<b>48,348.3</b>	<b>97.1%</b>	#	Үр дүн, зардлын зүйл	2020 он (мян. төг)			Төсөв	Гүйцэтгэл	Хувь	<b>1</b>	<b>НӨС-ний хөрөнгө оруулалт</b>	<b>22,695,049.4</b>	<b>22,217,315.7</b>	<b>97.9</b>		АХБ-ны Тусгай сан	18,505,635.6	18,501,784.7			АХБ-ны Энгийн эх үүсвэр	2,109,355.3	1,667,015.3			Сургалт	35,878.1	4,362.3			Зөвлөх үйлчилгээ	496,464.1	496,437.2			АХБ-ны зээлийн хүү	1,547,716.3	1,547,716.3		<b>2</b>	<b>Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх</b>	<b>2,483,547.4</b>	<b>1,644,989.7</b>	<b>66.2</b>		Ажил	1,661,035.0	1,213,051.4			Тоног төхөөрөмж, бараа материал	440,000.0	195,356.8			Сургалт, судалгаа	382,512.4	236,581.5		<b>3</b>	<b>ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</b>	<b>1,151,166.9</b>	<b>489,733.8</b>	<b>42.5</b>		Тоног төхөөрөмж, бараа материал	100,000.0	95,708.8			Сургалт, судалгаа	1,051,166.9	394,025.0		<b>4</b>	<b>Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт</b>	<b>808,472.8</b>	<b>309,445.7</b>	<b>38.3</b>		Сургалт, судалгаа	341,575.4	104,746.3			Брэнд хөгжүүлэх ажиллагаа	466,897.4	204,699.4		<b>5</b>	<b>Төслийн удирдлага</b>	<b>478,560.7</b>	<b>310,638.4</b>	<b>64.9</b>		<b>Нийт дүн</b>	<b>27,616,797.2</b>	<b>24,972,123.4</b>	<b>90.4</b>
Үр дүн	Төслийн нийт																																																																																																																																						
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь																																																																																																																																				
<b>1. АХБ-ны санхүүжилт</b>																																																																																																																																							
1. Нэмүү ертгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх	44,870.7	44,715.5	99.7%																																																																																																																																				
2. Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг	1,744.8	1,001.7	57.4%																																																																																																																																				
3. ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	1,794.5	1,610.8	89.8%																																																																																																																																				
4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт	674.1	415.7	61.7%																																																																																																																																				
5. Төслийн удирдлага	727.5	604.6	83.1%																																																																																																																																				
<b>АХБ-ны дүн</b>	<b>49,811.6</b>	<b>48,348.3</b>	<b>97.1%</b>																																																																																																																																				
#	Үр дүн, зардлын зүйл	2020 он (мян. төг)																																																																																																																																					
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь																																																																																																																																			
<b>1</b>	<b>НӨС-ний хөрөнгө оруулалт</b>	<b>22,695,049.4</b>	<b>22,217,315.7</b>	<b>97.9</b>																																																																																																																																			
	АХБ-ны Тусгай сан	18,505,635.6	18,501,784.7																																																																																																																																				
	АХБ-ны Энгийн эх үүсвэр	2,109,355.3	1,667,015.3																																																																																																																																				
	Сургалт	35,878.1	4,362.3																																																																																																																																				
	Зөвлөх үйлчилгээ	496,464.1	496,437.2																																																																																																																																				
	АХБ-ны зээлийн хүү	1,547,716.3	1,547,716.3																																																																																																																																				
<b>2</b>	<b>Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх</b>	<b>2,483,547.4</b>	<b>1,644,989.7</b>	<b>66.2</b>																																																																																																																																			
	Ажил	1,661,035.0	1,213,051.4																																																																																																																																				
	Тоног төхөөрөмж, бараа материал	440,000.0	195,356.8																																																																																																																																				
	Сургалт, судалгаа	382,512.4	236,581.5																																																																																																																																				
<b>3</b>	<b>ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</b>	<b>1,151,166.9</b>	<b>489,733.8</b>	<b>42.5</b>																																																																																																																																			
	Тоног төхөөрөмж, бараа материал	100,000.0	95,708.8																																																																																																																																				
	Сургалт, судалгаа	1,051,166.9	394,025.0																																																																																																																																				
<b>4</b>	<b>Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт</b>	<b>808,472.8</b>	<b>309,445.7</b>	<b>38.3</b>																																																																																																																																			
	Сургалт, судалгаа	341,575.4	104,746.3																																																																																																																																				
	Брэнд хөгжүүлэх ажиллагаа	466,897.4	204,699.4																																																																																																																																				
<b>5</b>	<b>Төслийн удирдлага</b>	<b>478,560.7</b>	<b>310,638.4</b>	<b>64.9</b>																																																																																																																																			
	<b>Нийт дүн</b>	<b>27,616,797.2</b>	<b>24,972,123.4</b>	<b>90.4</b>																																																																																																																																			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ХХААХҮЯ, салбаруудын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын																																																																																																																																					

	ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна. Мөн аймгуудын ХХААГ, Мал эмнэлгийн газартай ажлын уялдаа холбоотой ажиллаж байна.					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ):	Биелэлт дундаж (2019 он)	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		86.5%	4	100%	77.5 %	90%	83.3%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	<b>Нэгдсэн үнэлгээ</b>					
		...%					

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн шалгуур үзүүлэлт, гүйцэтгэл**

Төлөвлөж буй зорилт, суурь үзүүлэлтүүд	Тоон үзүүлэлтүүд						ХШҮ, %	Тайлбар
	Хүрэх үр дүн	Суурь үзүүлэлт	2016-2018	2019	Нийт *	Хувь		
<b>Үр дүн 1. НӨС-ний хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдэнэ.</b>								
1.a. 2020 оны 4-р улирал гэхэд <b>50</b> орчим НӨС-ний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ.	50	12	27	10	49	<b>98%</b>	100	Төсөл 2016-2019 онд боловсруулах салбарын нийт 37 ААН-ийн 86.9 тэрбум₮-ийн зээл батлагдан, 37 ААН-д 86.1 тэрбум₮-ийн зээлийг олгов.
1.b. 2020 оны 3-р улирал гэхэд <b>50</b> орчим НӨС-ний хөрөнгө оруулалтын дэд төслийн урьдчилсан үнэлгээг хийж дуусгана.	50	16	32	15	63	<b>100%</b>	100	2019 онд 15 төслийн саналын иж бүрэн үнэлгээ (санхүү, бизнес, нийгэм жөндөр, байгаль орчин)-г хийсэн.
1.c. 2020 оны 2-р улирал гэхэд давхардсан тоогоор ТООАН-дийн <b>800</b> ажилтан, ТОВ-дын <b>120</b> ажилтныг санхүү, нийгэм, байгаль орчны чиглэлээр тавьдаг заавал биелүүлэх шаардлага, жөндөр, мониторингийн чиглэлээр сургасан байна. Эдгээр ажилтны <b>40%-наас доошгүй</b> нь эмэгтэйчүүд байна.	920	332	1,797	796	<b>2,925</b> <b>51.4%</b>	<b>100%</b>	100	Төслөөс нийт ТООАН-ийн 1972, ТОВ-ын 953 төлөөлөл (давхардсан тоогоор) нийт 2,925 хүнд төсөл боловсруулах, санхүү, байгаль орчин болон нийгэм, жөндөрийн шаардлагууд, үнэлгээний явц, журмын талаар сургалт явуулж, зохих ойлголт, мэдлэг өгсөн. Үүний <b>51.4%</b> буюу 1,502 нь эмэгтэйчүүд байв.
<b>Үр дүн 1 -ийн хэрэгжилт</b>							<b>100</b>	
<b>Үр дүн 2. Малчдын үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэнэ.</b>								
2.a. Төслөөс дэмжлэг авсан малчид, фермерийн <b>120</b> хоршоодын үйлдвэрлэл 2020 оны 4-р улирал гэхэд <b>20</b> -иос доошгүй хувиар нэмэгдэнэ.	120	104	18	18	<b>122</b>	<b>100%</b>	100	ТТ-ны төслийн дэмжлэг авсан зөгийн аж ахуйн 13, ноос ноолуурын 5 хоршоодын үйлдвэрлэл 2017 онтой харьцуулахад 42.5% болон 66%-иар өссөн.
2.b. 2019 оны 4-р улирал гэхэд давхардсан тоогоор <b>5,500</b> -аас доошгүй малчин, фермер, анхан шатны боловсруулагчид, орон нутгийн засаг захиргааны төлөөллийг сургалтад хамруулна. Эдгээр төлөөллийн <b>40%</b> нь эмэгтэйчүүд байна.	5500	4320	1,140	1,768	<b>7,228</b> <b>54.3%</b>	<b>100%</b>	100	Малчид, хоршоод, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхжуулах чиглэлээр 2019 онд ноос ноолуур, арьс шир, мах, зөгий, сүү, чацарганын салбарын сургалтуудад (давхардсан тоогоор) нийт 607 хоршоод, ААН-ийн 1768 хүн (50.6% нь эмэгтэй) хамруулсан.
<b>Үр дүн 2 -ын хэрэгжилт</b>							<b>100</b>	
<b>Үр дүн 3. ААН-үүдийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамж сайжирна.</b>								
3.a. 2020 оны 4-р улирал гэхэд давхардсан тоогоор ТООАН-дийн 800 ажилтныг маркетинг болон техникийн чиглэлээр сургах ба үүнээс 40-өөс доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.	800	350	954	769	<b>2,073</b> <b>70.7%</b>	<b>100%</b>	100	2019 онд оёдол, арьс шир, ноос ноолуур, чацаргана, зөгий, махны салбарын (давхардсан тоогоор) 373 ААН-ийн 769 ажилтныг маркетинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бүтээгдэхүүний чанарын хяналт зэрэг чиглэлээр сургасан (үүний <b>77.2%</b> нь эмэгтэйчүүд).
3.b. 2019 оны 4-р улирал гэхэд ноос, ноолуур, арьс, ширний салбарын аж ахуйн нэгжүүдэд зориулсан техникийн удирдамж, гарын авлагыг шинэ боловсруулан гаргана.	2	0	-	5	<b>5</b>	<b>100%</b>	100	Ноос ноолуурын салбарын “Монгол ноолууран сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулалт” “Монгол ноолууран нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалт”, “Ноос ноолуурын будах технологи”, “Чанарын баталгаажилтын гарын авлага”, арьс ширний салбарын “Арьс шир боловсруулалтад ашиглагддаг химийн бодисууд” зэрэг техникийн удирдамж гарын авлагуудыг боловсруулсан.

Төлөвлөж буй зорилт, суурь үзүүлэлтүүд	Тоон үзүүлэлтүүд						ХШҮ, %	Тайлбар
	Хүрэх үр дүн	Суурь үзүүлэлт	2016-2018	2019	Нийт *	Хувь		
3.с. Чацарганын салбарын гадаад зах зээлийн судалгаа, Ойрхи Дорнодын махны зээл заалийн судалгааг 2019 оны 4-р улирал гэхэд хийж дуусгана.	2	0	-	2	2	100%	100	“Ойрхи Дорнодын улсуудын махны зах зээлийн судалгаа” болон “Чацарганы бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа”-ны ажлуудыг бүрэн гүйцэтгэж ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгсөн.
<b>Үр дүн 3 -ын хэрэгжилт</b>							<b>100</b>	
<b>Үр дүн 4. Монголын бүтээгдэхүүний брэндийг хөгжүүлнэ.</b>								
4.а. 2020 оны 4-р улирал гэхэд наад тал нь 3 Монголын компани олон улсын брэндтэй Брэндийн түншлэлийн гэрээ байгуулна.	3	0	-	1	1	33%	40	Одоогоор 3 ААН эцсийн бүтээгдэхүүн болон самнасан ноолуурт МХШ тэмдгийг авсан. Эдгээрээс 1 ААН МХШ форумын үеэр ОУ-ын түнштэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
<b>Шалгуур үзүүлэлтийн биелэлт</b>							<b>85.0</b>	

\*2015 оны суурь үзүүлэлтийг оруулж тооцсон

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР